

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН 1ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГТ 2024 ОНД
ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендрийн нэр: Өвөрхангай аймгийн Богд сумын 1дүгээр цэцэрлэгт 2024 онд
Цэцэрлэгийн хүүхдийн хоол нийлүүлэх тендер

Тендрийн дугаар:ӨВАБСЦ1/20240202001

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Өвөрхангай аймгийн Богд сумын Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 1 дүгээр цэцэрлэг нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **2024 онд Цэцэрлэгийн хүүхдийн хоол** /мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, хүнсний бусад бүтээгдэхүүн/ нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000** \тавин мянга\ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой

Дотоодын давуу эрхийн зөрүү **тооцно**.

Тендерийг **2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 14 цаг 40** минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2023 оны 02 дугаар сарын 23 -ний өдрийн 14 цаг 40** минутад нээнэ.

Өвөрхангай аймгийн Богд сумын Засаг даргын тамгын газар

Соёлын төвийн 2-р давхарт

Утас: 88451126 , 99470516

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА	
1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ	4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн санал тохируулна. Үүнд: \мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн\
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

<p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p>	<p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p>
<p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p>	<p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p>

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга. - Улсын бүргэлийн гэрчилгээний хуулбар. (улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагаа эрхлэх чиглэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах заалт байх) - Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, (2022 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан, 2023 оны санхүүгийн тайланг) ирүүлнэ. 2023 оны тайлан нь е-тайлан цахим системд шивэгдэн баталгаажсан байна. - Ижил төстэй бараа бүтээгдэхүүн борлуулдаг байх. - Сүүлийн 2 жилд ашигтай ажилласан байх ба борлуулалтын орлого нь тухайн багцад санал болгож буй багцын төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй буюу дээш байх - Санал ирүүлж буй тухайн багцад хамаарах бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломж, нөөцийн тооцоо, нотлох баримтын хамт. (Зоорь, агуулах, хөргүүр, зориулалтын тээврийн хэрэгсэл, өөрийн эзэмшлийн тариалангийн талбай гэх мэт) эдгээр нь давуу тал болно. - Харилцагч банкуудын хугацаа хэтэрсэн өр, зээлгүйн тодорхойлолт. - Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ)-аас эсвэл Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mnсайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. - Нийгмийн даатгалын байгууллагад өр төлбөргүй талаар тодорхойлолт. - Баталгаажсан баталгаат жин. (Стандартчилал, хэмжил зүйн газрын баталгаажуулсан гэрчилгээний хуулбар ирүүлэх, хүчинтэй хугацаа дуусаагүй байх) - Тохиролын гэрчилгээний хуулбар. Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт.

	<p>Тендерт оролцогч нь:</p> <p>1.Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/-т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>2.Захиалагч шалгарсан тендерт оролцогчийн талаар санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх</p> <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Өвөрхангай аймгын Богд сумын ЗДТГазар Соёлын төвийн 2-р давхарт, Санхүүгийн өрөөнд 88451126, 99470516</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 14 цаг 40 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Огноо: 2024 оны 02 дугаар сарын 23- ны өдөр Цаг: 14 цаг 40 минут</p> <p>Байгууллагын хаяг: Богд сумын Соёлын төвийн 2-р давхарт Утас: 88451126, 99470516</p>
ТӨӨЗ 6.1	<p>Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: /Багцтай/</p> <p>Багц 1: Сүү, сүүн бүтээгдэхүүн 9,780.100 төгрөг Багц 2: Махан бүтээгдэхүүн 19,557.000 төгрөг Багц 3: Хүнсний үндсэн бүтээгдэхүүн 27,892.300 төгрөг (хүнсний ногоо болон бусад)</p> <p>Төсөвт өртөг 57,229.400 төгрөг</p>
ТӨӨЗ 6.3	<p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад Мах махан бүтээгдэхүүнд техникийн тодорхойлолтод заасан нөхцөл үүссэн бол тохируулга хийж болно.</p>

Гурав.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ЗОРИЛГО: Цэцэрлэгийн хүүхдийг эрүүл, аюулгүй, амин дэмээр баялаг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, зөв зохистой хоололтонд шилжүүлж, өсөлт хөгжлийг дэмжинэ.

ЗОРИЛТ:

- ❖ Хүнс нийлүүлэх байгууллагыг оновчтой сонгоно.
- ❖ Хүнс нийлүүлэгч байгууллагаас зах зээлийн хамгийн бага боломжит үнээр хүнсний бүтээгдэхүүнийг авч, төсвийн хэмнэлт үүсгэнэ.
- ❖ Хүнс нийлүүлэгч байгууллагаас эрүүл ахуйн болон хүнсний аюулгүй байдлын тухай зохих хууль, дүрэм, журам, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг баталсан хуваарийн дагуу хүлээн авна.

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИХ ШААРДЛАГА:

- ❖ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байна.
- ❖ Хүнсний бүтээгдэхүүн нь шинжилгээний бичигтэй байна.
- ❖ Хүүхдийн эрүүл мэнд, дур сонирхолд нийцсэн байна.
- ❖ Орон нутагт хийгдсэн шинэ гурилан бүтээгдэхүүн байх.
- ❖ Нийлүүлж буй бүтээгдэхүүн нь сав, баглаа боодол, шошготой байх.
- ❖ Бараа, бүтээгдэхүүн нь гарал үүслийн болон лабораторийн бичигтэй байх.
- ❖ Бараа бүтээгдэхүүнийг өдөр тутам нийлүүлэх боломжтой байх.
- ❖ Хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын байгууллагаас гарсан шаардлага шалгуурт нийцсэн байна.
- ❖ Хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацааг нарийвчлан бүртгэж, бүртгэл хөтөлдөг байх.
- ❖ Байгууллагаас гаргасан хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажлын төлөвлөгөө, хуваарийг маш сайн барина.
- ❖ Гэрээгээр хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлнэ.
- ❖ Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтмол барина.
- ❖ Гарал үүслийн бичигтэй байх. (мах, сүү г.м)
- ❖ Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинэжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинэжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцна.
- ❖ Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байх.
- ❖ Чанарын стандартын шаардлага хангаагүй (норсон, хатсан, хөгцөрсөн, жин дутуу, гашилж ээдсэн, сав баглаа боодол гэмтэж урагдаж цоорсон), хугацаа дууссан бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд тухайн барааг үл маргах журмаар сольж өгнө.

Техикийн тодорхойлолтын хураангуй:

Нийлүүлэх бүтээгдэхүүн нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

д/д	Бүтээгдэхүүний нэр	Техникийн тодорхойлолт болон стандарт
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Малын сүү, тараг, аарц байна.
2	Махан бүтээгдэхүүн	Эрүүл монгол малын мах түүнтэй дүйцэхүйц, зөөлөн чанартай мах байна. Технологийн дагуу хадгалж хөлдөөсөн байна.
3	Гурил гурилан бүтээгдэхүүн	Эх орны үйлдвэрийн (түүнтэй дүйцэхүйц) 1-р сортын гурил байна. Зориулалтын сав баглаа боополтой байх. Өдөр бүр шинэ бүтээгдэхүүнээр хангах.
4	Жимс жимсгэнэ, Хүнсний ногоо	Эх орны хөрсөнд тарьж ургуулсан (түүнтэй дүйцэхүйц) экологийн цэвэр бүтээгдэхүүн нэр хаяг, шошиго нь тодорхой байх. Хугацаа дуусаагүй, чанарын болон эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилгээнд хамрагдсан байх.
5	Будаа (шар, цагаан, гурвалжин) элсэн сахар	Сайн чанарын, нэр хаяг, шошиго нь тодорхой байх. Мэргэжлийн хяналтын газрын бичигтэй байх.

Барааны тодорхойлолт:

- 1. Стандарт:** Стандартын шаардлага хангасан байна.
- 2. Бараа хүргэх газар:** Өвөрхангай аймаг Богд сумын 1 дүгээр Цэцэрлэгийн хүнсний агуулах байрлах газарт няравт хүргэнэ.
- 3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Х/н	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сүүн бүтээгдэхүүн	Сүүн бүтээгдэхүүн	140 228 194 738	Кг Литр Шир Хайцаг	1-р цэцэрлэгийн хүнсний агуулах няравт	Гэрээ байгуулсан өдөр	Дараагийн тендер зарлагдах хүртэл	

Махан бүтээгдэхүүн	Махан бүтээгдэхүүн	2131	кг	1-р Цэцэрлэгийн хүнсний агуулах, няравт	Гэрээ байгуулсан өдөр	Дараагийн тендер зарлагдах хүртэл	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	Үр тариа түүгээр хийсэн бүтээгдэхүүн	991.2 2029 153	Кг Уут Боодол	1-р Цэцэрлэгийн хүнсний агуулах, няравт	Гэрээ байгуулсан өдөр	Дараагийн тендер зарлагдах хүртэл	
	Хүнсний ногоо	828 110	Кг шил				
	Жимс жимсгэнэ	167.6 40 60	Кг Литр шил				
	Чихэр чихэрлэг бүтээгдэхүүн	82.1 28	Кг шил				
	Бусад	142 62 61 26	Уут Пакет Литр Боодол				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |

**10. Үүргээ
биелүүлээгүй
-гээс гэрээг
цуцлах**

10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11. Маргааныг
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]